

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/70/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: d.Chantsaldulamp@audit.gov.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас: 261740 Цахим хаяг: Telmuung@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн
Захирал: Ц.Жигдэн
Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Төслийн үйл ажиллагаа.....	9
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БСҮХАА	Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын алба
ГХНЦ	Гадаад худалдааны цахим нэг цонх
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
СЯ	Сангийн яам
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.10 № 06/1056
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн нийт санхүүжилт нь 29.0 сая ам.доллар бөгөөд тайлант оны эцэст нийт зээлийн ашиглалт өссөн дүнгээр 11.4 сая ам.доллар буюу 39.3 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Хилийн цэргийн 0119 дүгээр анги” ТӨААТҮГ-тай 2023 оны 06 дугаар сарын 30-нд байгуулсан гэрээгээр Бичигт хилийн боомтын барилга угсралтын ажлыг 2025 оны 06 дугаар сарын 30-нд дуусгах байсан боловч тайлант оны эцсээр 10.0 хувийн гүйцэтгэлтэй байсан тул 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөр гэрээг цуцалсан. Гүйцэтгэчийг дахин

сонгон шалгаруулах, барилга угсралтын ажлын төсвийг шинэчлэх зэрэг шаардлага үүссэн тул төслийн зээлийн хаах хугацааг сунгах, төсөвлөгдөөгүй нэмэлт зардал, гадаад зээлийн өр төлбөр нэмэгдэх эрсдэл үүссэн байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,432,816,998.13	457,963,524.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,298,430,462.96	456,991,279.14
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,298,430,462.96	456,991,279.14
31211	Төрийн сангийн харилцах/төгрөг/	24,505,535.92	2,124,767.88
31221	Төрийн сангийн харилцах/валют/	2,273,924,927.04	454,866,511.26
34	УРЬДЧИЛГАА	956,710.00	972,156.00
34600	Урьдчилж гарсан зардал	956,710.00	972,156.00
35	БАРАА МАТЕРИАЛ	862,886.85	89.85
35400	Хангамжийн материал	862,886.85	89.85
35410	Бичиг хэргийн материал	450,000.00	-
35440	Түлш шатах тослох материал	412,886.85	89.85
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	27,132,566,938.32	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	27,132,566,938.32	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,480,759.88	8,067,821,186.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,480,759.88	8,067,821,186.39
39200	Биет хөрөнгө	3,480,759.88	1,972,267.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,362,999.50	23,362,999.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,205,466.54)	(23,362,999.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,509,600.00	3,509,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,186,373.08)	(1,537,332.88)
39400	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	8,065,848,919.27
39405	Дуусаагүй барилга, байгууламж	-	8,065,848,919.27
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,436,297,758.01	8,525,784,711.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	15,352,756.22	1,395,705.11
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,352,756.22	1,395,705.11
41300	Өглөг	15,352,756.22	1,395,705.11
41361	Бусад өглөг	15,352,756.22	1,395,705.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	29,420,945,001.79	8,524,389,006.27
51	Засгийн газрын хувь оролцоо	29,420,945,001.79	8,524,389,006.27
51200	Хуримтлагдсан үр дүн	29,420,945,001.79	8,524,389,006.27
51210	Өмнөх үеийн үр дүн	26,285,260,047.21	29,420,945,001.79
51220	Тайлант үеийн үр дүн	3,135,684,954.58	(20,896,555,995.52)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	29,436,297,758.01	8,525,784,711.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	8,330,707,832.13	931,584,792.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,330,707,832.13	931,584,792.50
120	Нийтлэг татварын бус орлого	8,330,707,832.13	931,584,792.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,329,094,832.13	931,584,792.50
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,932,260,848.65	725,284,760.42
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,396,833,983.48	-
120009	Бусад орлого	1,613,000.00	206,300,032.08
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,093,549,129.73	21,919,045,788.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	799,580,526.63	740,370,049.59
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	799,580,526.63	740,370,049.59
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	375,259,810.20	413,355,272.63
210101	Үндсэн цалин	375,259,810.20	413,355,272.63

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,944,513.53	51,667,909.10
210201	Нийгмийн даатгалын зардал	46,944,513.53	51,667,909.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,570,990.00	87,722,727.27
210301	Гэрэл цахилгаан	-	25,200,000.00
210304	Байрны түрээс	78,570,990.00	62,522,727.27
2104	Хангамж, бараа материалын зардал	14,111,866.99	12,062,895.00
210401	Бичиг хэргийн материал	2,694,302.69	820,273.14
210402	Тээвэр, шатахуун	4,033,000.50	5,120,812.61
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	5,435,713.80	5,379,409.25
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн зүйлс	1,948,850.00	742,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,449,540.91	9,678,991.79
210604	Урсгал засвар	2,449,540.91	9,678,991.79
2107	Томилолт, зочны зардал	40,368,746.71	21,030,603.50
210702	Дотоод албан томилолт	40,368,746.71	21,030,603.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	229,478,316.57	142,905,715.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,478,316.57	108,317,101.94
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	33,000,000.00	33,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	1,588,613.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,396,741.72	1,945,934.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	437,442.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	12,396,741.72	1,508,492.76
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,293,968,603.10	21,178,675,738.70
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	4,293,968,603.10	21,178,675,738.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	3,237,158,702.40	(20,987,460,995.79)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	45,855,120.07	103,452,514.62
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	45,855,120.07	103,452,514.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	147,328,867.89	12,547,514.35
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	98,591,590.66	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	48,737,277.23	12,547,514.35
145001	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(101,473,747.83)	90,905,000.27
5	НИЙТ ҮР ДҮН	3,135,684,954.58	(20,896,555,995.52)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,932,660,848.65	725,284,760.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,932,660,848.65	725,284,760.42
120	Нийтлэг татварын бус орлого	6,932,660,848.65	725,284,760.42
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,932,260,848.65	725,284,760.42
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,932,260,848.65	725,284,760.42
120009	Бусад орлого	400,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	771,762,053.02	723,710,330.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,762,053.02	723,710,330.08
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	771,762,053.02	723,710,330.08
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	375,259,810.20	413,355,272.63
210101	Үндсэн цалин	375,259,810.20	413,355,272.63

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,944,513.53	51,667,909.10
210201	Нийгмийн даатгалын зардал	46,944,513.53	51,667,909.10
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	71,427,272.76	80,181,818.16
210301	Гэрэл цахилгаан	-	22,909,090.92
210304	Байрны түрээс	71,427,272.76	57,272,727.24
2104	Хангамж, бараа материалын зардал	11,646,771.69	9,560,735.69
210401	Бичиг хэрэг	2,397,445.45	335,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,400,000.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,947,976.24	4,929,935.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,901,350.00	695,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,271,227.27	8,833,374.35
210604	Урсгал засвар	2,271,227.27	8,833,374.35
2107	Томилолт, зочны зардал	39,672,880.00	20,556,441.11
210702	Дотоод албан томилолт	39,672,880.00	20,556,441.11
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	224,539,577.57	139,117,337.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	194,539,577.57	107,659,101.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	30,000,000.00	30,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,458,236.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	437,442.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	437,442.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,160,898,795.63	1,574,430.34
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	8,825,863,574.03	1,933,918,614.43
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,825,863,574.03	1,933,918,614.43
2200	Дотоод эх үүсвэрээр	8,825,863,574.03	1,933,918,614.43
220001	Барилга байгууламж	4,849,375,531.41	1,341,123,252.42
222001	Тоног төхөөрөмж	3,976,488,042.62	592,795,362.01
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(8,825,863,574.03)	(1,933,918,614.43)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	45,855,120.07	103,452,514.62
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	45,855,120.07	103,452,514.62
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	48,737,277.23	12,547,514.35
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	48,737,277.23	12,547,514.35
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(2,882,157.16)	90,905,000.27
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,667,846,935.57)	(1,841,439,183.82)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,966,277,398.52	2,298,430,462.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,298,430,462.95	456,991,279.14

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	26,285,260,047.21	26,285,260,047.21
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
9	Тайлант үеийн үр дүн	3,135,684,954.58	3,135,684,954.58
10	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	29,420,945,001.79	29,420,945,001.79
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
19	Тайлант үеийн үр дүн	(20,896,555,995.52)	(20,896,555,995.52)
20	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	8,524,389,006.27	8,524,389,006.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
3	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,720,430,000.00	2,657,628,944.51	(62,801,055.49)	98.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	778,930,000.00	723,710,330.08	(55,219,669.92)	93.0
210	Бараа, үйлчилгээний зардал	778,930,000.00	723,710,330.08	(55,097,884.37)	93.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,327,000.00	413,355,272.63	(16,971,727.37)	96.0
210101	Үндсэн цалин	430,327,000.00	413,355,272.63	(16,971,727.37)	96.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,850,000.00	51,667,909.10	(7,182,090.90)	88.0
210201	Нийгмийн даатгалын зардал	58,850,000.00	51,667,909.10	13,067,909.10	134.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,185,000.00	80,181,818.16	(2,003,181.84)	97.0
210301	Гэрэл цахилгаан	23,483,000.00	22,909,090.92	(573,909.08)	97.0
210304	Байрны түрээс	58,702,000.00	57,272,727.24	(1,429,272.76)	97.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,240,000.00	9,560,735.69	(4,679,264.31)	67.0
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	335,200.00	(2,664,800.00)	11.0
210402	Тээвэр шатахуун	3,600,000.00	3,600,000.00	-	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5,340,000.00	4,929,935.69	(410,064.31)	92.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,300,000.00	695,600.00	(1,604,400.00)	30.0
2106	Эд хогшил худалдан авах	8,860,000.00	8,833,374.35	(26,625.65)	99.0
210604	Урсгал засвар	8,860,000.00	8,833,374.35	(26,625.65)	99.0
2107	Томилолт, зочны зардал	40,258,000.00	20,556,441.11	(19,701,558.89)	51.0
210702	Дотоод албан томилолт	40,258,000.00	20,556,441.11	(19,701,558.89)	51.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	144,210,000.00	139,239,122.59	(4,970,877.41)	96.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,080,000.00	107,780,886.59	(3,299,113.41)	97.0
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	30,000,000.00	30,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,458,236.00	(41,764.00)	97.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,200,000.00	-	(1,200,000.00)	-
210806	Мэдээллийн технологийн зардал	430,000.00	-	(430,000.00)	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,941,500,000.00	1,933,918,614.43	(7,581,385.57)	99.0
220001	Барилга байгууламж	1,341,500,000.00	1,341,123,252.42	(376,747.58)	99.0
222001	Тоног төхөөрөмж	600,000,000.00	592,795,362.01	(7,204,637.99)	98.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-	(1,932,344,184.09)	1,932,344,184.09	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,932,344,184.09	(1,995,145,239.58)	27.0
7	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,720,430,000.00	725,284,760.42	(1,995,145,239.58)	27.0

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

72	Засгийн газрын зээл	2,720,430,000.00	725,284,760.42	(1,995,145,239.58)	27.0
722	Гадаад	2,720,430,000.00	725,284,760.42	(1,995,145,239.58)	27.0
7221	Төслийн зээл	2,720,430,000.00	725,284,760.42	(1,995,145,239.58)	27.0
322101	Шинээр авах	2,720,430,000.00	725,284,760.42	(1,995,145,239.58)	27.0
101	Төсвийн гүйцэтгэлийн тохируулга	-	90,905,000.27	(90,905,000.27)	-
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-	1,841,439,183.82	(1,841,439,183.82)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,298,430,462.96	(2,298,430,462.96)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	456,991,279.14	(456,991,279.14)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
7	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
7.1	АЖИЛЛАГСДЫН ТОО	11	7	4	64.0
7.2	Гүйцэтгэх ажилтан	11	7	4	64.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төслийн үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн Газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2019 оны 10 дугаар сарын 02-ний өдөр байгуулсан хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээгээр Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийг 2019 оны 07 дугаар сараас 2024 оны 06 дугаар сарыг дуустал хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн боловч хэрэгжилтийн явцад төслийн хугацааг 2 удаа сунгаж 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр төслийн үйл ажиллагаа болон зээлийн хугацааг хаахаар товлосон байна.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төсөл нь хилийн үйлчилгээг сайжруулах замаар гадаад худалдааг илүү шуурхай, боловсронгуй болгох, бараа эргэлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдаа эрхлэхэд зарцуулж буй зардал, цаг хугацааг бууруулах зорилготой байна.

Төслийн хүрэх үр дүн:

1. Бичигт, Боршоо хилийн боомтын барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх, шинээр зам барих, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэх;
2. Чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (хил дээр хяналт хэрэгжүүлдэг холбогдох байгууллагуудад зориулсан сургалтууд үүнд хамаарна);

3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажилладаг.

Журмын 1.2-т “Журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Иргэний хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно” гэж заасны дагуу үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 174 тоот “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам” зэрэг болно.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Сангийн Яамны Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт, үнэлгээний газраас тус ТХН-ийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтын үр дүнг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 08 болон 11 тоот тогтоолоор засаглах болон гүйцэтгэх удирдлагад танилцуулсан байна. Шалгалтаар 7 зөвлөмж өгөгдсөнийг ТХН төлөвлөгөө гаргаж, заасан хугацаанд биелүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл Хэрэгжүүлэх Нэгж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 21 дүгээр бүлэг Гадаад зээл, тусламжийн бүртгэл, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,910,513.0 мянган төгрөгөөр буюу 71.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,298,430.5	456,991.3	(1,841,439.2)
Урьдчилгаа	956.7	972.1	15.4
Бараа материал	862.9	-	(862.9)
Бусад эргэлтийн хөрөнгө	27,132,566.9	-	(27,132,566.9)
Биет хөрөнгө	3,480.7	1,972.3	(1,508.4)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	8,065,849.0	8,065,849.0
Нийт хөрөнгө	29,436,297.7	8,525,784.7	(20,910,513.0)
Богино хугацаат өр төлбөр	15,352.7	1,395.7	(13,957.0)
Цэвэр хөрөнгө ба эзэмшигчийн өмч	29,420,945.0	8,524,389.0	(20,896,556.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	29,436,297.7	8,525,784.7	(20,910,513.0)

Дээрх үзүүлэлтээс харахад дараах данстуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Тухайлбал,

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 456,991.3 мянган болж, өмнөх оноос 1,841,439.2 мянган төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс нийт 725,284.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаанд 723,710.3 мянган төгрөгийг, хөрөнгийн зардалд 1,933,918.6 мянган төгрөгийг зарцуулж, 12,547.5 мянган төгрөгийн

валютын ханшийн зөрүүний гарзыг, 103,452.5 мянган төгрөгийн валютын ханшийн зөрүүний олзыг тус тус хүлээн зөвшөөрч бүртгэснээс голлон нөлөөлсөн;

- Урьдчилж гарсан зардлын үлдэгдэл 972.1 мянган төгрөг болж, 15.4 мянган төгрөгөөр өссөн нь авто машины даатгалын төлбөрийг төлсөнтэй холбоотой;
- Бусад эргэлтийн хөрөнгө тайлант онд Боршоо боомтын барилга байгууламжийг өртгөтгөн шинэчлэх ажлын гүйцэтгэл 797,813.2 мянган төгрөг, Бичигт боомтын барилгын ажлын гүйцэтгэл 984,144.5 мянган төгрөг, Боршоо боомтын ухаалаг гарцын төхөөрөмж суурилуулах ажлын 330,000.0 мянган төгрөг, нийт 2,111,957.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын даргын 2025 оны 660 дугаар тогтоолоор Увс аймгийн Боршоо боомтод 21,083,154.6 мянган төгрөгийн хөрөнгө, ГЕГ-ын даргын 2025 оны А/32 тоот тушаалаар хилийн боомтуудын хаяг 95,521.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн өгч, боомтуудад баригдаж буй барилга байгууламж, замын ажлын гүйцэтгэлийн хуримтлагдсан 8,065,849.0 мянган төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилга, байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгэж, үлдэгдэлгүй тайлагнагдсан;
- Биет хөрөнгийн үлдэгдэл 1,508.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тооцсон элэгдлийн зардлаар буурсан;
- Өр төлбөрийн үлдэгдэл 13,957.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд тооцсон НӨАТ-ын чөлөөлөлтийг хөрөнгийн өртөгт бүртгэсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төсөл нь 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээлийн 2,720,430.0 мянган төгрөгөөр бүрдүүлж, барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх зардалд 1,341,500.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 600,000.0 мянган төгрөг, зөвлөх үйлчилгээний зардалд 144,210.0 мянган төгрөг, ТХН-ийн урсгал зардалд 634,720.0 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөж батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гадаадын зээл тусламжийн санхүүжилтээс гүйцэтгэлээр 2,657,628.9 мянган төгрөг буюу 97.7 хувийн санхүүжилт авсан байна.

ТХН-ээс хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний нийт зардлын гүйцэтгэл 2,657,628.9 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
70207	Гадаад тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	2,720,430.0	2,657,628.9	62,801.1	97.7
80104	ТХН-н үйл ажиллагааны зардал	634,720.0	584,155.5	50,564.5	93.4
80105	Зөвлөх үйлчилгээний зардал	144,210.0	139,554.8	4,655.2	96.7
80918	Хөрөнгийн зардал	1,941,500.0	1,933,918.6	7,581.4	99.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудитораас баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл”-ийн хүрээнд тус төсөл хэрэгжүүлэгч нэгжээс авсан судалгаанд дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

- Тайлант онд 11 ажиллагсадтай байхаар орон тоо баталснаас гүйцэтгэлээр 7 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулсан;
- Гадаад томилолтоор ажиллаагүй, хэвлэл мэдээллийн байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээт ажил хийгдээгүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Нэмэлт санхүүжилтийн төслийн (МОН-3810) хүрээнд 2019 онд батлагдсан “Төсөл хэрэгжүүлэхэд баримтлах гарын авлага”-н Төлөвлөлт, хяналт мониторингийн хүрээ (ТХМХ)-д тусгаснаар үндсэн төсөл болон нэмэлт санхүүжилтийн хэсгийн зорилт, бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэсэн тул төслийн хэрэгжилтийн тайланг 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нэгтгэн 25 үйл ажиллагаа явуулахаар гаргасан ба хэрэгжилт 75.7 хувьтай гэж ТХН-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үнэлэгдсэн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Бүрэлдэхүүн хэсгийн нэр	Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд тайлант онд хийгдэх ажлын тоо	Хэрэгжилтийн хувь
1	Бүрэлдэхүүн 1. Хилийн боомтуудын барилга байгууламж, дэд бүтцийг өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмж шинэчлэх	20	48.2
1.1	Бичигт хилийн боомтын барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх угсралтын ажил гүйцэтгэх	3	10.0*
1.2	Бичигт хилийн боомтын авто зам, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэх	3	7.2
1.3	Боршоо боомтын барилга угсралтын ажлын явцад хяналт хийх ажлыг гүйцэтгэх	3	8.3
1.4	Боршоо боомтын авто зам, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэх	3	8.3
1.5	Бичигт болон Боршоо боомтын барилга угсралтын ажлын явцад хяналт тавих ажлыг гүйцэтгэх	3	10.8
1.6	Хилийн хяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалтыг явуулах	5	3.7
2	Боомтын чадавхыг бэхжүүлэх	2	19.2
2.1	Төслийн бичиг баримтад тусгагдсан, төслийн хэрэгжилтэд зайлшгүй шаардлагатай зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах, ажлыг гүйцэтгүүлэх	1	4.5
2.2	Боомтын чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнүүд	1	14.7
3	Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн менежментийг сайжруулах	3	8.3
3.1	ТХН-ийн хүний нөөцийг бэхжүүлэх, ажиллах байрыг тохижуулах	1	5.0
3.2	ТХН-ийн үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжилтэд хяналт тавих		3.3
	НИЙТ ДҮН	25	75.7

Бичигт хийлийн боомтын барилга байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэгч “Хилийн цэргийн 0119 анги” ТӨААТТҮГ-тэй 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан гэрээг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр цуцалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Төсөл Хэрэгжүүлэх Нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг сайжруулахтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Номин, аудиторын туслах С.Булганчимэг, Б.Хонгорзул нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер М.Болормаа, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр төслөөс ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын эх сурвалжаар 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 21,919,045.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 219,190.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч нэгж 2025 оны төсвийг зарцуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төслийн Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулах мэдээллийг МОН-3387 дугаартай үндсэн төслийн шилэн дансны цахим хуудсанд нэгтгэн байршуулдаг болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 226,036.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,680,246.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг таслан зогсоох 4 албан шаардлагын шийдвэрийн хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	226,036.3	1	226,036.3	100
Албан шаардлага	4	2,680,246.5	4	2,680,246.5	100
Нийт дүн	5	2,906,282.8	5	2,906,282.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл, арга хэмжээний ихэнх гэрээт ажлын явц гэрээний хугацаанаас хоцорч хэрэгжиж байгаа ба гэрээний сунгалт 2-3 удаа хийгдэж, зарим гэрээ цуцлагдах нөхцөл гарч байна. Хугацаа хоцорсон шалтгааныг тодорхойлж, хоцролт үүсгэсэн гүйцэтгэгч байгууллагад тодорхой хариуцлага тооцох, мөн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ хугацааны алданги тооцох заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Төслийн үйл ажиллагаагаар баригдаж буй барилга байгууламж, авто зам, гадна шугам сүлжээний ажлын төсөвт өртгийн тооцоо буруу хийгдсэнээс төсөвлөгдөөгүй ажил үйлчилгээ нэмэгдэх, үүнийг дагаад төсөвлөгдөөгүй нэмэлт зардал гарах, аль эх үүсвэрээс санхүүжүүлэх зэрэг эрсдэл үүсэхээр байгааг дараагийн аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн дараах зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг хэмжээний зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1. Гэрээний хэрэгжилтэд тавих хяналттай холбоотой

Илрүүлэлт: Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа хангалтгүйгээс гэрээ цуцлагдах, төсөл, арга хэмжээний хугацаа сунгагдах, зураг төсөвт өөрчлөлт орох зэрэг асуудлууд гарч байгаа нь төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болсон байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 4.1.2-д “төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх”, 7.9-д “Төслийн зохицуулагч нь төсөл хэрэгжүүлэх нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна: 16.4.16-д “Засгийн газрын шугамаар авч байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн нэгжийн дарга тухайн төслийн” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Зөвлөмж: Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг сайжруулж, ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа хангалтгүйгээс гэрээ цуцлагдах, төсөл, арга хэмжээний хугацаа сунгагдах, зураг төсөвт өөрчлөлт орох зэрэг асуудлууд гарч байгаа нь төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болсон байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Нийт	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-